

**“МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ  
БАРИМТЛАЛ /2016-2030 ОН/ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН  
ТӨСЛИЙГ АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААР БАЙГАЛЬ ОРЧИН,  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2016 оны 02 дугаар  
сарын 02-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд**

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Б.Гарамгайбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь МАХН-МҮАН-ын “Шударга ёс эвсэл”-ийн бүлгийн дарга Н.Батцэрэг нараар ахлуулсан нам, эвслийн бүлэг, бие даагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын нэр бүхий 10 гишүүдээс Улсын Их Хуралд 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал /2016-2030 он/ батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2016 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороодод шилжүүлсэн болно.

Тус Байнгын хороо 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ж.Энхбаяр нар ажлын хэсгээс асуулт асууж, хариулт авсан ба Улсын Их Хурлын гишүүн С.Оюун байгаль орчны тогтвортой хөгжлийн асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх болон хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар тус тус зарчмын зөрүүтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.


Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийн хамт Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал /2016-2030 он/ батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ  
АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Л.ЭРДЭНЭЧИМЭГ**

**“МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ  
БАРИМТЛАЛ /2016-2030 ОН/ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН  
ТӨСЛИЙН ТАЛААР БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ГИШҮҮДЭЭС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН  
ТОМЬЁОЛОЛ**

**Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:**

1. Үзэл баримтлалын төсөлд заасан “унаган байгаль, экологийн тогтвортой байдлыг хадгалсан” гэснийг “хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалсан” гэж, 2.3, 2.3.3-т заасан экосистемийн тогтвортой байдал” гэснийг “экосистемийн тэнцвэрт байдал” гэж тус тус өөрчлөх.

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Оюун, Су.Батболд**

2. Үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд гэсэн хэсгийн “14. Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хувь” гэснийг “14. Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээ” гэж өөрчлөн, хэмжих нэгжийг га, суурь түвшин (2014)17.4%, зорилтот түвшин (2030) 30% болгох.

3. Төслийн “2.3.2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуй” гэсэн хэсгийн зорилт 1 ба зорилт 3-ыг нэгтгэн зорилт, хүрэх үр дүнг дараах байдлаар томьёолох. Үүнд: Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бүрдүүлж, цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ.

**Үе шат 1- (2016-2020):** Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулж хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийн менежментийн чадавхийг бэхжүүлж, байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, эрт илрүүлэх, урьдчилан мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгох.

**Үе шат 2- (2021-2025):** Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох жишиг төслүүдийг хэрэгжүүлж сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд тогтмол зохион байгуулах.

**Үе шат 3- (2026-2030):** Уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын үр дагаврыг зөөлрүүлж, гамшгийн эрсдэл, түүнээс үүдэлтэй хохирлыг бууруулах.

4.2.3.2 дахь хэсгийн зорилт 2-ийн **Үе шат 1- (2016-2020):** Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, нүүрс, занарыг шингэрүүлэх, хийжүүлэх дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон

хэмжээнээс 2 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, батламж авсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог 2 дахин нэмэгдүүлэх.” гэснийг **Үе шат 1- (2016-2020)**: Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, хэмнэлттэй, үр ашигтай, дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 2-оос доошгүй хувь бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14000 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, сертификат авсан аж ахуй нэгж, байгууллагын тоог 2 дахин нэмэгдүүлэх” гэж өөрчлөн найруулах.

**5.2.3.3 дахь хэсгийн Зорилт 1.** Байгальд ээлтэй төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлж, байгалийн унаган төрхийг хамгаалж, цөлжилтийг сааруулан экосистемийн тогтвортой байдлыг хадгална. гэснийг Зорилт 1. Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална. гэж өөрчлөн хүрэх үр дүнг дараах байдлаар томъёолох. Үүнд:

**Үе шат 1- (2016-2020)**: Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 25 хувьд, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.5 хувьд хүргэх

**Үе шат 2- (2021-2025)**: Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 27 хувьд, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.7 хувьд хүргэх

**Үе шат 3- (2026-2030)**: Цөлжилтийг сааруулж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 30 хувьд, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 9.0 хувьд хүргэх гэж өөрчлөх.

**6.Төслийн 2.1.1 дэх хэсгийн Зорилт 1-ийн “нэмэгдүүлэх” гэсний дараа “бэлчээрийн даацад нийцсэн” гэж, “харьцааг бүрдүүлж” гэсний дараа “бэлчээрийн газрын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх” гэж тус тус нэмэх.**

**7.Төслийн 2.3.3 дахь хэсгийн Зорилт 2-ын Хот суурины ногоон байгууламжийн төлөвлөлтийг боловсронгуй болгож, хог хаягдлын менежментийг сайжруулна. гэснийг Зорилт 2. Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлж, хүрээлэн байгаа орчны чанарыг сайжруулна гэж өөрчлөх.**

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Оюун**

**8.Төслийн 2.1.1 дэх хэсгийн Зорилт 2-ын Үе шат 1- (2016-2020):-ийн 3 хувьд гэснийг 10 хувь, Үе шат 2- (2021-2025):-ын 5 хувьд гэснийг 20 хувь, Үе шат 3 – (2026-2030):-ын 8 хувьд гэснийг 30 хувь гэж өөрчлөх.**

**9.Төслийн 2.1.5 дахь хэсгийн Зорилт 5-ын Үе шат 1- (2016-2020):-д**  
Нийслэлийг нүүлгэн шилжүүлэх асуудлыг судалж, дүгнэлт гаргах, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах гэж нэмэх

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр**